



2025

Эхний хагас
жилийн тайлан

Агуулга

01

Бизнесийн үйл
ажиллагаа

02

Санхүүгийн
үзүүлэлтүүд

03

Онцлох үйл
явдлууд

04

Эрсдэлийн
удирдлага

05

Компанийн
засаглал

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “ЛэндМН” гэх) нь технологиор дамжуулан санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор үйл ажиллагаагаа явуулдаг финтек байгууллага билээ. Энэхүү зорилгын хүрээнд бид Монгол Улсын эдийн засгийн тулгуур хүч болох бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд (цаашид “БЖДБ” гэх) зориулан уян хатан, хүртээмжтэй санхүүгийн экосистемийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Тэдгээр бизнесүүд нь санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бүрэн хэмжээнд хүртэх боломж хязгаарлагдмал байгааг харгалзан үзэж, илүү хүртээмжтэй шийдлүүдийг бий болгох нь бидний зорилт юм. Үүний хүрээнд бид 2025 оны эхний хагас жилд дараах ажлуудыг хийгээд байна:

FlexiBusiness зээлийн бүтээгдэхүүний нөхцлийг улам сайжруулж, хүртээмжийг тэлсээр байна.

Энэхүү бүтээгдэхүүн нь Монголд анх удаа барьцаа хөрөнгө шаардахгүйгээр гар утсаараа дамжуулан 5хан минутын дотор бизнесийн зээл авах боломжийг бий болгосон билээ. Уг бүтээгдэхүүнийг 2024 онд зах зээлд нэвтрүүлснээс хойш ЛэндМН нь харилцагчдын хэрэгцээ шаардлагад тулгуурлан бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт, зээлийн эрх тооцоолох, зээл авах аргачлалаа тасралтгүй сайжруулсаар байна. Зээлийн доод дүнг 5 сая төгрөгөөс 500 мянган төгрөг болгон бууруулсан нь бичил бизнесүүдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлсэн. Хиймэл оюун ухаанд суурилсан KYB (Know Your Business) моделийн тусламжтайгаар харилцагчийн аппликейшнд оруулсан мэдээллийг боловсруулж, бизнесийн

онцлогт тулгуурласан зээлжих чадварыг тооцоолох болсон. Ингэснээр бид илүү оновчтой шийдвэр гаргаж, илүү олон бизнес эрхлэгчдэд хүрч ажиллахыг зорьж байна.

LendDy - Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх шинэ платформыг нэвтрүүлээд байна.

Монгол Улсад нийт аж ахуйн нэгжийн 93 хувийг бүрдүүлдэг БЖДБ нь эдийн засгийн тогтвортой байдал, хөдөлмөр эрхлэлтийн чухал хэсэг юм. Иймээс ЛэндМН нь худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг БЖДБ эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх боломжийг эрэлхийлсний үндсэн дээр санхүүгийн дэвшилтэт шийдэл болох “LendDy”-г нэвтрүүлээ.

LendDy нь бизнесүүдэд:

- Борлуулалтын эргэцийг нэмэгдүүлэх
- Эргэлтийн хөрөнгөө оновчтой удирдах
- Төлбөр тооцооны сувгаа өргөжүүлэх боломжийг олгож байна.

Харин хэрэглэгч талд:


Өдөр тутмын бараа үйлчилгээг худалдан авахдаа урьдчилгаагүй, эхний 30 хоногт хүүгүй, хүссэн үедээ төлөх Санхүүгийн дарамтгүй, хурдан, уян хатан худалдан авалт хийх боломжийг санал болгож байгаа юм. LendDy-д хамрагдах бизнес эрхлэгчид нь **өөрийн биеэр ирэх шаардлагагүй** бөгөөд зөвхөн LendMN аппликейшн ашиглан **цахимаар гэрээ байгуулаад** борлуулалт хийх, төлбөр хүлээн авах, ажилтнуудаа удирдах зэрэг бүх

процессыг нэг дор шийдвэрлэх юм. LendDy үйлчилгээ зах зээлд нэвтэрснээс хойш ердөө хоёрхон сарын хугацаа өнгөрөөд байгаа хэдий ч энэ хугацаанд нийт 1,500 бизнес эрхлэгч шинээр бүртгүүлж, хамтын ажиллагаагаа амжилттай эхлүүлээд байна.

Бидний зүгээс FlexiBusiness, LendDy болон бусад бүтээгдэхүүн, үйлчилгээгээ улам боловсронгуй болгож, бизнес эрхлэгчдэд санхүүгийн шинэ гарц нээхийг зорин ажиллаж байна. **Цаашид ч бид бичил, жижиг, дунд бизнесүүдийн өсөлтөд хувь нэмрээ оруулсан, Монголын санхүүгийн салбарт технологид суурилсандэвшилтэт шийдлүүдийг түгээсээр байх болно.**


ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2025 оны эхний хагас жилийн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал



Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Аудитлагдаагүй/

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /тэрбум төгрөг/	2023H1	2024H1	2025H1
Нийт орлого	20.7	39.7	62.1
Хүүгийн зардал	(4.1)	(9.1)	(17.0)
Цэвэр орлого	16.6	30.6	45.1
Зээлийн үйл ажиллагаатай холбоотой зардал	(2.1)	(2.3)	(2.6)
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(1.2)	(1.4)	(11.0)
Үйл ажиллагааны цэвэр орлого	13.3	26.9	31.5
Удирдлагын болон ҮА-ны зардал	(2.9)	(4.2)	(6.0)
Татварын өмнөх ашиг	10.4	22.7	25.5
Татварын зардал	(2.1)	(5.6)	(5.2)
Цэвэр ашиг	8.3	17.1	20.3

Санхүү байдлын тайлан /Аудитлагдаагүй/

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2023H1	2024H1	2025H1
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	7.5	18.9	9.9
Зээлийн багц (цэвэр)	82.3	173.0	269.1
Бусад хөрөнгө	2.9	7.5	6.9
Үндсэн хөрөнгө	0.8	1.5	4.8
Биет бус хөрөнгө	0.4	0.3	0.7
Нийт хөрөнгө	93.8	201.2	291.4

Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/

Өр төлбөр	62.6	147.3	209.3
Эх үүсвэр	52.2	130.9	182.8
Бусад өглөг	7.6	13.6	23.7
Хоёрдогч өглөг	2.8	2.8	2.8
Эздийн өмчийн дүн	31.2	53.9	82.1
Хувьцаат капитал	8.5	8.5	8.5
Хуримтлагдсан ашиг	22.7	45.4	73.6
Нийт өр төлбөр болон эздийн өмч	93.8	201.2	291.4

2025 оны эхний хагас жилийн байдлаар зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь өмнөх оны мөн үеэс 2.2 нэгж хувиар өсөж 5.8 хувь хүрсэн ба зээлийн эрсдэлийн сангийн нөөц 20.6 тэрбум төгрөг буюу зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээг 128.1 хувьд хүргэж ажиллалаа.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

ЛэндМН нь зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт СТОУС 9 (IFRS 9)-н дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу 2025 оны эхний хагас жилийн байдлаар 7.0 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС 9 (IFRS 9) стандартын дагуу 20.6 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулсан.

Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 128.1%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлаар компанийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хэлэлцдэг бөгөөд зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилладаг болно.

Тухайлбал, Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 10.0 хувиас доошгүй байх шаардлагатайгаас 24.7%, Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа 20.0 хувиас доошгүй байх шаардлагатайгаас 25.6%, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 8.0 хувиас дээш байх шаардлагатайгаас 8.9% тус тус байна.



2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



Азийн санхүүгийн байгууллагуудын хамгийн нэр хүндтэй форум болох AFIForum - Asia Financial Institutions Forum 2025 арга хэмжээнд ЛэндМН нь Брэндинг Ивээн Тэтгэгчээр оролцлоо. Энэхүү арга хэмжээ нь санхүүгийн салбарын тэргүүлэгчид, хөрөнгө оруулагчдыг нэгтгэж, тогтвортой санхүү болон инновацийн ирээдүйг хамтдаа хэлэлцдэг чухал ач холбогдолтой юм.




Тайландын Бангкок хотод зохион байгуулагдсан дэлхийн санхүү, технологийн хамгийн том арга хэмжээ болох Money 20/20 Asia форумд Монгол Улсаас анх удаа ЛэндМН-ийн Дэд захирал Д.Баасандорж илтгэл тавьж, Монголын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн (MSME) санхүүгийн хүртээмжийг хиймэл оюун ухаанд суурилсан, бүрэн дижитал B2B зээлийн шийдлээ танилцууллаа.




ЛэндМН нь Олон Улсын Үнэлгээний MFR Global Rating Agency (MFR) -с “Харилцагчийг Хамгаалах Сертификат” авсан дэлхийн анхны финтек компани боллоо. MFR Олон Улсын Үнэлгээний Байгууллага нь санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг шударга, ил тод байдлын 8 үндсэн зарчмын дагуу үнэлж Алт, Мөнгө, Хүрэл түвшинд ангилдаг бөгөөд ЛэндМН нь Мөнгөн түвшний стандартыг хангаж, гэрчилгээгээ албан ёсоор авснаар финтекийн салбарт энэхүү гэрчилгээг авсан дэлхийн анхны тохиолдол болж, шинэ жишгийг тогтоогоод байна.



ЛэндМН нь олон улсын мэргэжлийн хөрөнгө оруулагч болох Lendable Asset Management байгууллагаас 20 сая ам.долларын урт хугацаат санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүллээ. Энэхүү санхүүжилт нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тэр дундаа бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг тогтвортой, урт хугацааны санхүүжилтээр хангах зорилготой юм.



ЛэндМН нь 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа амжилттай зохион байгуулж, Хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 81.64% нь оролцож, 6 асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэлээ.



ЛэндМН-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар нэгж хувьцаанд 15 төгрөг буюу Компанийн 2024 оны цэвэр ашгийн 30.62%, нийт 11,089,525,245 төгрөгийн ногдол ашгийг олгохоор шийдвэрлэсний дагуу 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-д байршууллаа.



Монголын Эдийн засгийн гол тулгуур болсон Бичил, жижиг, дунд бизнес (БЖДБ) эрхлэгчдийг дэмжих зорилгоор ЛэндМН нь Монголын Бизнесийн Зөвлөлтэй хамтран “Бичил, Жижиг, Дунд Бизнесийг чадавхжуулах нь” арга хэмжээг зохион байгуулж, БЖДБ-ийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, өсөлт хөгжилд нь дэмжлэг үзүүлэх талаар хэлэлцүүлэг өрнүүлээ.



ЛэндМН нь санхүү, бизнесийн салбарын боловсон хүчин бэлтгэдэг СЭЗИС-тай санамж бичиг байгуулж, салбарын судалгаа, мэргэжлийн хөгжил, оюутны дадлага, ажлын байр, эрдэм шинжилгээ зэрэг олон чиглэлд стратегийн түвшинд хамтран ажиллахаар боллоо.



Монгол Улс “Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн код” хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд ЛэндМН нь тус хөтөлбөрт нэгдэж, эмэгтэйчүүдийн санхүүгийн хүртээмжийг сайжруулахад өөрсдийн хувь нэмрийг оруулах боломж дахин нэгээр нэмэгдэж байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

“ЛэндМН ББСБ” ХК нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, харилцагчид болон хамтран ажиллагч нарынхаа итгэлийг хүлээж бизнесийн ёс зүйг эрхэмлэн ажиллаж, сайн засаглалын хүрээнд Эрсдэлийн Удирдлагын тогтолцоог бүрдүүлж ажиллаж байна.

Манай компанийн хувьд ОУ-ын стандартын дагуу эрсдэлийн “Хамгаалалтын гурван бүс”-ийг тодорхойлон компанийн бүх нэгжүүдийн чиг үүрэг, төлөвлөгөө, гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулан ажиллаж байна.

Хамгаалалтын 1-р бүсэд: Бизнесийн болон тэдгээрт дэмжлэг үзүүлэх нэгж-Эрсдэлийг хариуцаж, удирдах эзэн буюу нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой гарах эрсдэлийг тодорхойлох, илрүүлэх, хариу арга хэмжээ авах, хяналтад байлгах, удирдах.

Хамгаалалтын 2-р бүсэд: Эрсдэл, хяналт хариуцсан нэгж- Хамгаалалтын 1-р бүсийн эрсдэлийн удирдлага, хяналтын зохион байгуулалт, үйл ажиллагаанд мониторинг хийх, заавар, зөвлөмжөөр хангах.

Хамгаалалтын 3-р бүсэд: Дотоод аудитын нэгж Хамгаалалтын 2-р бүсийн тавьж буй хянан нийцүүлэлт, үнэлгээ, тайлагналын үр дүнтэй байдалд хараат бус үнэлэлт, дүгнэлт өгөх.

“ЛэндМН ББСБ” ХК нь Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын дүрэм журмыг даган мөрдөж, тэдгээрийг үйл ажиллагаандаа нийцүүлснээр санхүүгийн үнэн зөв, ил тод тайлагнал, үйл ажиллагааны үр дүнтэй байдал, урт болон богино хугацааны стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад байгууллагын ажилтан нэг бүрийн оролцоотойгоор хэрэгжүүлэх, тасралтгүй хөгжих системийг бий болгон ажиллаж байна.

Комплаенсийн эрсдэлийн удирдлагын хүрээнд дараах үндсэн 2 чиг үүргийг үйл ажиллагаагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд хүлээсэн үүргээ биелүүлж Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 25/35 дугаар тогтоолоор “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтын хөтөлбөр”-ийг шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

2. Монгол Улсын хэмжээнд шинэчлэгдсэн, нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагын дүрэм журамд орсон өөрчлөлтийг тухай бүр өөрийн компанийн дотоод бодлого, журамд нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг оруулж, үйл ажиллагаагаа нийцүүлэн ажиллаж байна.

ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЛэндМН-ийн дотоод аудитор нь байгууллагын дотоод хяналтын тогтолцоог оновчтой, үр дүнтэй байлгах, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар үнэ цэнийг нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна. Дотоод аудитор нь хараат бус аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлж, ажлын тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд тайлагнадаг ба Гүйцэтгэх удирдлагыг шаардлагатай мэдээллээр ханган ажиллаж байна.

Дотоод аудитор нь Дотоод Аудиторууд-

ын Олон Улсын Институт (ДАОУИ)-ээс гаргасан Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ (International Professional Practice Framework) болон олон улсын сайн туршлагыг үйл ажиллагаандаа удирдамж, жишиг болгон ажиллаж байна. Мөн COSO-н зарчмын дагуу дотоод хяналтын тогтолцоог үнэлж, аливаа ашиг сонирхлын зөрчлөөс ангид, бодитой, шударга байх зарчмыг баримтлан ажиллаж байна. Компанийн эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог схемээр харуулбал:



Дотоод аудитор нь хамгаалалтын гуравдугаар бүсэд хамаардаг бөгөөд нэг ба хоёрдугаар бүсийн хүрээнд хяналтын шаардлагууд биелж байгаа эсэхийг хараат бус, бодитой үнэлж дүгнэн

баталгаажуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд тайлагнах, Гүйцэтгэх удирдлагад зөвлөгөө өгч хамтран ажиллах үүрэг хүлээдэг.

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр: "ЛэндМН ББСБ"	МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал: I ангилал
Хэлбэр: Нээлттэй хувьцаат компани	Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг: 800,000,000
Регистрийн дугаар 5039754	Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо: 8,975 (2025.03.31-ний өдрийн тархалтын судалгаагаар)
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага: Монголын хөрөнгийн бирж	Үндсэн үйл ажиллагааны чиглэл: Зээлийн үйл ажиллагаа
Үнэт цаасны код: LEND	

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ЛэндМН нь Монгол Улсын хууль тогтоомж болон Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй, нээлттэй хувьцаат компани болохынхоо хувьд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж болон бусад зохицуулагч байгууллагаас баталсан холбогдох дүрэм, журам, засаглалын кодексыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

ЛэндМН нь зохистой засаглал, засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангахад онцгойлон анхаарч, улмаар Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдлагын баг болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцааг төгөлдөржүүлэх, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн урт хугацаанд тогтвортой үнэ цэнийг бий болгохыг үргэлж зорьсоор байна.

ЛэндМН-ийн зүгээс хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болон харилцагчдын

эрх ашгийг хамгаалах, оролцогч талуудтай үр дүнтэй холбоо үүсгэх, санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөв, цаг алдалгүй хүргэх зорилгоор үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн талаар улирал, хагас жил, жилийн эцсийн хугацааг хамруулан мэдээлэх стратегийг баримтлан ажиллаж, тухай бүр тайлан бэлтгэж олон нийтэд хүргээд байна.

Тодруулбал, 2024 оны жилийн эцсийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр, 2024 оны Байгаль орчин, Нийгэм Засаглалын тайланг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр, 2025 оны I улирлын тайланг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр тус тус гарган олон нийтэд мэдээлснээр Компанийн бизнес, засаглал, байгаль орчин, санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийн талаарх мэдээллийг тухай бүр авах боломжийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагчид болон оролцогч талуудад олгож, харилцан итгэлцэл, эргэх холбоо

бүхий хамтын ажиллагааг бий болгоход анхаарч ажилласан болно.

Мөн 2025 оны эхний хагаст багтаан 2024 оны БОНЗ-ын тайланг анх удаа гарган МХБ болон олон нийтэд мэдээлсэн нь онцлох үйл явдал боллоо. Тус тайлангийн зорилго нь тогтвортой байдлын талаар компанийн баримталж буй бодлого, байгаль орчин, нийгэмд үзүүлж буй нөлөөллийг олон нийтэд ил тод хүргэх явдал бөгөөд

компани нь цаашид жил бүр БОНЗ-ын тайланг гаргаж, олон нийтэд мэдээлэн ажиллахыг зорьж байна.

2025 оны хагас жилийн хугацаанд ЛэндМН-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллалаа.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид "ТУЗ") нь ЛэндМН-ийн үйл ажиллагааг бэхжүүлэх, зохистой түвшинд удирдах, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг хэрэгжүүлэх, стратегийн зорилтдоо хүрэхэд ЛэндМН-ийг ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихын зэрэгцээ Гүйцэтгэх захиралд компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн ЛэндМН-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн ердийн 6, хараат бус 3 гишүүнийг улируулан сонгосон. ТУЗ-ийн ердийн 6 гишүүнээр Монгол Улсын иргэн О.Болдбаатар, Ц.Ууганбаяр, Б.Хос-Эрдэнэ, Ц.Одмаа, С.Энх-Амгалан, Япон Улсын иргэн Кацухико Мадоно нар сонгогдсон бол ТУЗ-ийн Хараат бус 3 гишүүнээр Монгол Улсын иргэн Ж.Жаргалсүрэн, С.Боргил, С.Нэргүй нар тус тус улиран сонгогдсон болно. Ийнхүү ТУЗ-ийн 2025 оны 05 дугаар

сарын 09-ний өдрийн ээлжит хурлаар ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн даргыг тус тус улираан сонгож, ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн болон ТУЗ-ийн 2025 оны ээлжит хурлын хуваарь, ажлын төлөвлөгөөг шинэчлэн баталлаа.

ТУЗ нь 2025 оны хагас жилд 2 удаа ээлжит хурал, 3 удаа эчнээ санал хураалт явуулан нийт 35 тогтоол гаргажээ. ТУЗ-ийн тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлээд байна.

ТУЗ-ийг эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд ЛэндМН-ийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг, байнгын ажиллагаа бүхий 1) Эрсдэл ба БОНЗ-ын удирдлагын хороо, 2) Аудитын хороо, 3) Засаглал, нэр дэвшүүлэх хороо, 4) Цалин, урамшууллын хороод үйл ажиллагаа явуулж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

Эрсдэл ба БОНЗ-ын удирдлагын хороо (цаашид “ЭБОНЗУХ”)

ЭБОНЗУХ нь 2025 оны эхний хагас жилд нийт 2 удаа хуралдаж, ЛэндМН-ийн бизнесийн хөгжил, эрсдэл болон эх үүсвэрийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг оновчтой удирдан чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нөхцөл байдалтай тухай бүр танилцан хэрэгжилтэд хяналт тавих болон БОНЗ-ын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

ЭБОНЗУХ-ны бүрэлдэхүүн: ЭБОНЗУХ-ны даргаар ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Нэргүй, гишүүдээр ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Хос-Эрдэнэ, Ц.Ууганбаяр, Кацухико Мадоно, С.Энх-Амгалан нар ажиллаж байна.

Аудитын хороо

Аудитын хороо нь 2025 оны хагас жилд нийт 2 удаа хуралдаж, ЛэндМН-ийн дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудиторыг томилохтой холбоотой дүгнэлт гаргах, дотоод аудиторын үйл ажиллагааны тайлантай тухай бүр танилцан шаардлагатай санал, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд болон ЛэндМН-ийн газар, хэлтэс, албадад өгч ажиллалаа. Түүнчлэн, ЛэндМН-ийн зүгээс хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргах, Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байлгахад анхаарч мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэж буй эсэхэд хяналт тавьж ажилласан байна.

Аудитын хорооны бүрэлдэхүүн: Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн Хараат бус

гишүүн Ж.Жаргалсүрэн, гишүүдээр ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Боргил, ТУЗ-ийн Ердийн гишүүн Ц.Одмаа нар ажиллаж байна.

Засаглал, нэр дэвшүүлэх хороо (цаашид “ЗНДХ”)

ЗНДХ нь 2025 оны эхний хагас жилд нийт 2 удаа хуралдаж, ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлж, шаардлага хангаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, ердийн болон хараат бус гишүүдийг улируулан сонгох болон ТУЗ-ийн 2025 оны төсвийн асуудлыг Компанийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хуралд танилцуулан шийдвэрлүүлэх тухай асуудлыг хэлэлцэж ажилласан байна.

ЗНДХ-ны бүрэлдэхүүн: ЗНДХ-ны даргаар ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Боргил, гишүүдээр ТУЗ-ийн Хараат бус гишүүн Ж.Жаргалсүрэн, ТУЗ-ийн Ердийн гишүүн О.Болдбаатар нар ажиллаж байна.

Цалин, урамшууллын хороо (цаашид “ЦУХ”)

ЦУХ нь 2025 оны эхний хагас жилд нийт 2 удаа хуралдаж, ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх захирлын цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг баталж, цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоон, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулан ажилласан байна.

ЦУХ-ны бүрэлдэхүүн: ЦУХ-ны даргаар ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Нэргүй, гишүүдээр ТУЗ-ийн Хараат бус гишүүн С.Боргил, ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Одмаа нар ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн бүрэлдэхүүн



О.Болдбаатар
ТУЗ-ийн дарга

Мэргэжил: Санхүүч, Аудитор, ОУ-ын мэргэшсэн нягтлан бодогч
ИРО Консалтинг Пти.Лтд, ТУЗ-ийн гишүүн;
АНД Глобал Пти.Лтд, ТУЗ-ийн гишүүн;
АНД ФСЖ Пти.Лтд, Гүйцэтгэх захирал;
“ОНДО Холдинг” ХХК-ийн ТУЗ-ийн дарга;
“ОНДО” ХХК-ийн ТУЗ-ийн дарга.



Ц.Ууганбаяр
ТУЗ-ийн ердийн гишүүн

Мэргэжил: Санхүүч
АНД Глобал Пти.Лтд, Санхүү эрхэлсэн захирал;
АНД ФСЖ Пти.Лтд, Гүйцэтгэх захирал;
“АНД Системс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал;
“АНД Дэнууд” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн.



Б.Хос-Эрдэнэ
ТУЗ-ийн ердийн гишүүн

Мэргэжил: Санхүүч, Бизнесийн удирдлага
АНД Глобал Пти.Лтд,
Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн;
АНД ФСЖ Пти.Лтд, ТУЗ-ийн гишүүн;
АНД Сольюшн Пти.Лтд, ТУЗ-ийн гишүүн
“АНД Системс” ХХК-ийн ТУЗ-ийн дарга;
“АНД Дэнууд” ХХК-ийн ТУЗ-ийн дарга.



С.Энх-Амгалан
ТУЗ-ийн ердийн гишүүн

Мэргэжил: ОУ-ын бодлого судлаач
“Мэргэн Инвестмент” Пти.Лтд, ТУЗ-ийн гишүүн;
“Монложистикс Холдинг” ХК, ТУЗ-ийн гишүүн.



К.Мадоно
ТУЗ-ийн ердийн гишүүн

Мэргэжил: Бизнесийн удирдлага
“ЛэндМН ББСБ” ХК, Ерөнхийлөгч.



Ц.Одмаа
ТУЗ-ийн ердийн гишүүн

Мэргэжил: Хуульч, өмгөөлөгч
“ОНДО Холдинг” ХХК,
Хуулийн газрын захирал.



Ж.Жаргалсүрэн
ТУЗ-ийн Хараат бус гишүүн

Мэргэжил: Санхүүч, Аудитор, ОУ-ын мэргэшсэн нягтлан бодогч
“Бейкер Тилли Далайван аудит” ХХК,
Удирдлагын партнер / Гүйцэтгэх захирал.



С.Боргил
ТУЗ-ийн Хараат бус гишүүн

Мэргэжил: Эдийн засагч, санхүүч
“Сэргэлт консалтинг групп” ХХК,
Гүйцэтгэх захирал.



С.Нэргүй
ТУЗ-ийн Хараат бус гишүүн

Мэргэжил: Санхүүч,
Санхүүгийн мэргэшсэн зөвлөх
“Сургалт үнэлгээ судалгааны хүрээлэн”
НҮТББ, Захирал, Ахлах зөвлөх.

ТУЗ-ийн гишүүдийн ирц, ажилласан хугацаа болон бусад мэдээлэл

ТУЗ-ийн гишүүдийн нэрс	2025 оны эхний хагас жилийн ирц	ТУЗ-д ажилласан хугацаа, туршлага	ЛэндМН-д хувьцаа эзэмшдэг эсэх
О.Болдбаатар	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 8 дахь жилдээ ажиллаж байна	нийт хувьцааны 0.00726%
С.Энх-Амгалан	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 8 дахь жилдээ ажиллаж байна	нийт хувьцааны 0.085%
Кацухико Мадоно	80%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 2 дахь жилдээ ажиллаж байна	нийт хувьцааны 0.00281%
С.Нэргүй	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 2 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	нийт хувьцааны 0.00113%
Б.Хос-Эрдэнэ	80%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 4 дэх жилдээ ажиллаж байна	Үгүй
Ц.Ууганбаяр	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 4 дэх жилдээ ажиллаж байна	нийт хувьцааны 0.00255%
Ж.Жаргалсүрэн	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 8 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	Үгүй
С.Боргил	100%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 8 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна	нийт хувьцааны 0.00088%
Ц.Одмаа	80%	ХЭЭХ-аас улиран сонгогдож, 3 дахь жилдээ ажиллаж байна	Үгүй

ЛэндМН-ийн ТУЗ-ийн гишүүд нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн холбогдох журам, кодекс, түүнчлэн ЛэндМН-ийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд аливаа шийдвэрийг хараат бусаар, бие даан гаргадаг. ТУЗ-ийн аливаа шийдвэр нь олонхын саналаар хүчин төгөлдөр болдог ба ТУЗ-ийн гишүүн нь хэлэлцэж буй

асуудлаар “дэмжсэн”, “татгалзсан”, эсхүл “түдгэлзсэн” санал гаргах боломжтой. ТУЗ-ийн гишүүд нь тайлант хугацаанд ЛэндМН-ийн үйл ажиллагааг амжилттай эрхлэн явуулахад шаардлагатай, ач холбогдол бүхий шийдвэрүүдийг холбогдох баримт бичиг, судалгаа, тайлбар, дүгнэлттэй нэг бүрчлэн танилцсаны үндсэн дээр цаг алдалгүй гаргаж, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

ТУЗ-ийн хурлын тогтоол, төрөл болон бусад мэдээлэл

Шийдвэр гаргасан огноо	Ирц	Шийдвэр гаргасан хэлбэр	Баталсан тогтоолын тоо
2025 оны 02 дугаар сарын 06	88.89%	Ээлжит хурал	11
2025 оны 03 дугаар сарын 06	77.78%	Эчнээ санал хураалт	1
2025 оны 03 дугаар сарын 25	100%	Эчнээ санал хураалт	3
2025 оны 05 дугаар сарын 09	100%	Ээлжит хурал	17
2025 оны 06 дугаар сарын 18	100%	Эчнээ санал хураалт	3

Удирдлага зохион байгуулалт	Санхүү	Эрх олгох	Үйл ажиллагаа	Бизнес стратеги
6	10	3	8	8

2025 оны эхний хагас жилийн байдлаар Компанийн зээлийн үйл ажиллагааны өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангах, үйл ажиллагааг эрчимжүүлэх үүднээс санхүүжилт хүлээн авах, баталгаа гаргах болон Компани акталсан

тавилгыг худалдахтай холбоотойгоор нийт 3 сонирхлын зөрчилтэй хэлцэлд ЛэндМН-ийн ТУЗ-өөс Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрөл олгосноос 2 сонирхлын зөрчилтэй хэлцэл нь байгуулагдсан байна.

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ЫН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

ЛэндМН нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Компанийн засаглалын кодекс”, түүний зарчмуудыг Санхүүгийн зохицуулах хорооны нэгдсэн үнэлгээний хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар 87,5 хувьтай хэрэгжүүлэн ажиллаж, компанийн

засаглал болон соёлыг сайжруулан бэхжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа, арга хэмжээг тогтмол авч ажиллаж байна. 2025 оны сүүлийн хагаст Кодексын хэрэгжилтийг бүрэн хангахын тулд компанийн засаглалын ил тод байдлыг хангаж, ТУЗ-ийн ажлын болон сургалтын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэн ажиллахад анхаарах болно.

ЛЭНДМН-ИЙН УДИРДЛАГЫН БАГ



Ц.Ууганбаяр
Гүйцэтгэх захирал



К.Мадоно
Ерөнхийлөгч



Г.Мөнхтулга
Хөрөнгө оруулалт хариуцсан захирал



Н.Мөнхбат
Санхүү хариуцсан захирал



Ж.Сосор
Бизнес хөгжлийн газрын захирал



М.Түвшинжаргал
Үйл ажиллагааны газрын захирал



Х.Энхжаргал
Борлуулалт, хамтын ажиллагаа хариуцсан захирал



Э.Пунсалдулам
Тусгай активын хэлтсийн захирал




Д.Оюунчимэг
Хүний нөөц, соёлын хэлтсийн захирал



Б.Наранцацрал
Эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2025 оны эхний хагас жилд Lend хувьцааны ханш 179.79 төгрөг хүртэл өсөж, хагас жилийн эцсээр 140 төгрөгөөр хаагдсан байна.

- Нийт арилжаалагдсан ширхэг - 8.2 сая ширхэг
- Нийт арилжаалагдсан үнийн дүн - 1,257.88 сая төгрөг

Хувьцаа эзэмшигчид

АНД Системс ХХК	600,000,000
Олон нийт	139,301,683
Халаасны хувьцаа	60,698,317

ВЕБСАЙТ:

www.lend.mn

УТАС:

7722-2949

ИМЭЙЛ:

board@lend.m